



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/180

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 85 дугаар тогтоолоор баталсан Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын норматив”-ын 1 дүгээр хэсгийн 1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 3 сарын 16 -ны 03 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алсын хараа 2050 сургалтын үйл ажиллагаа, Японы Жайка олон улсын байгууллагаас үдийн хоолыг дэмжих төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмнэлэгийн нярайн мэс заслын эмч нар Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах үеийн үйл ажиллагаа, Амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх жилийн хүрээнд зохион байгуулагдсан “Эрчүүдээ хайрлая” үйл ажиллагааны зардал зэрэгт нийт 6,125,200 (зургаан сая нэг зуун хорин таван мянга хоёр зуу) төгрөг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 6,125,200 (Зургаан сая нэг зуун хорин таван мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М. Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823100488